

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

Салбарын ҮЭ-ийн холбооны Боловсрол сургалтын хороо нь энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Зорилго үйл ажиллагааны зарчим

Салбарын ҮЭ-ийн холбооны Боловсрол сургалтын хорооны үндсэн зорилго нь ҮЭ-ийн боловсролын бодлого, сургалтын үйл ажиллагааны чиг баримтлал боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

Гурав. Боловсрол сургалтын хорооны бүрэлдэхүүн

1. Салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчид, ажлын алба, ҮЭ-ийн хороодын багш-арга зүйч нараас бүрдэнэ.
2. Тус хороо нь Тэргүүлэгчид, даргатай нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба салбарын ҮЭ-ийн холбооны гишүүн ҮЭ-ийн хороодын багш-арга зүйчдээс бүрдэнэ.
3. Хороог байгуулах, татан буулгах, бүрэлдэхүүнийг батлах, өөрчлөлт оруулах асуудлыг салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчийн хурлаар шийдвэрлэнэ.

Дөрөв. Боловсрол сургалтын хорооны эрх, үүрэг

1. Хорооны Тэргүүлэгчдийн хурал нь улиралд нэгээс доошгүй удаа, шаардлагатай бол тухай бүр хуралдаж хэлэлцсэн асуудлуудаар зөвлөмж гаргаж ҮЭ-ийн хороодод хүргүүлж ажиллана. Мөн шаардлагатай тохиолдолд салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хуралд оруулж асуудлыг шийдвэрлүүлнэ.
2. Хорооны ажлыг дарга удирдах бөгөөд салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурал, Гүйцэтгэх хорооны хурал, Бага хуралд ажлын тайлан, санал дүгнэлтээ танилцуулна.
3. Хороо нь дотоод ажил хариуцсан нарийн бичгийн даргатай байх бөгөөд салбарын ҮЭ-ийн холбооны зохион байгуулагч уг ажлыг хариуцана.
4. Салбарын ҮЭ-ийн холбооны Боловсрол сургалтын сангаас санхүүжих бөгөөд үйл ажиллагааны төсвөө Гүйцэтгэх хорооны хуралдаанаар батлуулж ажиллана. Мөн үйл ажиллагаагаа жил бүр гишүүдэд тайлагнана.

---oOo---